

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



**2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2021 он**

АГУУЛГА

Нэг. Эрүүл мэндийн даатгалын хууль, тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт

- 1.1 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэр, авсан арга хэмжээ
 - 1.1.1. Эрүүл мэндийн даатгалын санг удирдах, нөөцийг зарцуулах талаар
 - 1.1.2. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар
 - 1.1.3 Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар
 - 1.1.4 УИХ-ын Байнгын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн биелэлт
 - 1.1.5 ЭМДҮЗ-ийн үйл ажиллагаа

Хоёр. Эрүүл мэндийн даатгалын сан

- 2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
- 2.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ
- 2.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт
- 2.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт, сангаас төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ

Гурав. Эрүүл мэндийн даатгалын хяналт, сургалт, сурталчилгаа

- 3.1 Дотоод хяналт
- 3.2 Цахим хяналт
- 3.3 Сургалт, сурталчилгаа

Дөрөв. Дүгнэлт, цаашдын бодлого, чиглэл

- 4.1 Эрүүл мэндийн даатгалын 2020 оны ажлын үр дүн
- 4.2 Ойрын зорилт, анхаарах асуудал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл
- Хүснэгт 2. Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүд
- Хүснэгт 3. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал
- Хүснэгт 4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл
- Хүснэгт 5. Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт зарцуулсан зардал
- Хүснэгт 6. Гемодиализийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй хувийн эмнэлгүүдийн гүйцэтгэл
- Хүснэгт 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл
- Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ
- Хүснэгт 9. Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал
- Хүснэгт 10. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон тусламж, үйлчилгээний зардал
- Хүснэгт 11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан даатгуулагчийн тоо, зарцуулсан хөрөнгө
- Хүснэгт 12. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо

График 2. Шалгалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллага

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
НББСШУ	Нийгмийн Бодлого Боловсрол Соёл Шинжлэх Ухаан
ЗХХАУБ	Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэл
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

ХАВСРАЛТ

- Хавсралт 1. ЭМДҮЗ-ийн тогтоолын жагсаалт, 2017-2020 он
- Хавсралт 2. УИХ-ын Байнгын хорооны шийдвэр, чиглэлийн биелэлт
- Хавсралт 3. ЭМД-ын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, 2017-2020 он

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл тайлант хугацаанд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон хэрэгжилтийг хангахад чиглэсэн зөвлөмж, шийдвэр гаргах, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг даатгуулагчид ойртуулж, илүү хүртээмжтэй, өгөөжтэй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг боловсронгуй болгоход анхаарлаа төвлөрүүлэн ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд эрүүл мэндийн даатгалын талаарх дүрэм журамд өөрчлөлт оруулан, шинэчлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авч, даатгалын сангийн хөрөнгийг зарцуулах орлого, зарлага, санхүүгийн байдалд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөх, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжилтийг хангалаа.

1.1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гаргасан шийдвэр, авсан арга хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эрүүл мэндийн даатгалын бодлогыг хэрэгжүүлж, иргэн бүрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс холбогдох тогтоол, шийдвэрүүдийг гарган мөрдүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2017 онд 3, 2018 онд 26, 2019 онд 30 тогтоол шийдвэр, заавар гаргасан бол 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх чиглэлээр 22 тогтоол шийдвэр гаргасан байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар 23 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. ЭМДҮЗ нь 2020 онд эрүүл мэндийн даатгалын санг удирдан чиглүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр 9, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийн талаар 10, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны тухай 1, ажлын албаны талаар 2 тогтоолыг батлан гаргаж, хэрэгжилтийг хангуулж байна. /ЭМДҮЗ-ийн тогтоолын жагсаалтыг хавсаргав. Хавсралт 1./

Тайлант хугацаанд Эмийн үнийн жагсаалт, “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц”-д орсон нэмэлт, өөрчлөлт, Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн зардлын төлбөр, хяналт тавих журам, жагсаалтыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүллээ.

1.1.1. Эрүүл мэндийн даатгалын санг удирдах, нөөцийг зарцуулах талаар

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд эрүүл мэндийн даатгалын санг удирдах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

а/ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны орлого 506.5 тэрбум төгрөг, зарлага 494.5 тэрбум төгрөгийн төсвийн нарийвчилсан хуваарилалтыг хийв. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 168 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлэх, эрсдэлийн сан байгуулах зэрэг арга хэмжээг авлаа.

б/ 2020 оны жилийн эцсийн байдлаар төрийн санд 108.7 тэрбум төгрөг төвлөрүүлэв. Арилжааны 9 банканд 158.5 тэрбум төгрөг харилцахын үлдэгдэлтэй байгаагаас эрсдэлтэй гэж үздэг банкуудын 54.5 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Сангийн яамтай хамтран тэргүүн ээлжинд төрийн санд төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Тайлант оны эцэст эрүүл мэндийн даатгалын сан 753.3 тэрбум /Капитал банкны 136.1 тэрбум төгрөг ороод/ төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 59.7 тэрбум төгрөг буюу 10.7 хувиар өссөн дүнтэй байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн
2020 оны жилийн эцсийн үлдэгдэл, тэрбум.төгрөг**

Хүснэгт.1.

№	Банкны нэр	Харилцах	Хадгаламж	Нийт дүн
1	Худалдаа хөгжлийн банк	8.8	110.0	118.8
2	Голомт банк	8.5	40.0	48.5
3	Төрийн банк	48.2	45.0	93.2
4	ҮХО-ын банк	25.4	0.0	25.4
5	Чингис хаан банк	29.1	0.0	29.1
6	Хаан банк	14.4	115.0	129.4
7	Төрийн сан	108.7	0.0	108.7
8	Худалдаа хөгжил банк-УБ	5.4	10.0	15.4
9	Хас банк	1.6	20.0	21.6
10	Капитрон банк	17.1	10.0	27.1
НИЙТ ДҮН		267.2	350.0	617.2
11	Капитал банк	136.1		136.1

Цар тахлын үед авах арга хэмжээний тухай хуульд зааснаар ЭМД-ын сангийн хөрөнгийг төрийн санд төвлөрүүлэх нь сангийн хөрөнгийг эрсдэлээс хамгаалж буй мэт боловч Сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг эргэлтэд оруулах замаар нэмэлт эх үүсвэр бүрдүүлж байсныг зогсоох байдалд хүргэж байна. Цаашдаа ч үнэт цаасны зах зээл, хөрөнгийн биржид оролцох болон банкны

найдвартай ажиллагаа хангагдсан нөхцөлд хадгаламж хэлбэрээр байршуулах нь сангийн хөрөнгийг арвижуулах нэг эх үүсвэр байж болохыг үгүйсгэж болохгүй гэж үзэж байна. Эрүүл мэндийн даатгалын санд 2018-2019 онд хадгаламжийн хүүгээс 90.0 тэрбум төгрөг орлого орж байв. Банканд хадгалуулсан хүүн дээр ашиг сонирхол, ашиг хүртэх тодорхой хүмүүсийн хариуцлагагүй ажиллагааг дахин гаргуулахгүй байх нөхцлийг сүүлийн 3 жилд Байнгын хорооноос удаа дараа өгсөн чиглэлээр үндсэнд нь зассан.

в/ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 2019 онд 31,6 тэрбум төгрөг, 2020 онд 41.7 тэрбум төгрөгийг төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Харин 2020 онд эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг 20.0 тэрбум төгрөгөөр байгуулсан. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 5 дугаар тогтоолоор ЭМД-ын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банкинд хадгалуулах журмыг баталсан. Энэ журамд “хүн амыг олноор хамарч, удаан хугацааны эмчилгээ шаардагдах өвчний тархалтыг шуурхай таслан зогсооход шаардлагатай нэмэлт тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх” гэсэн заалт тусгагдсаныг үндэс болгож, коронавируст халдварын цар тахал манай улсад зөөвөрлөгдөн тархах хэлбэрээс голомтлон тархах хэлбэрт шилжиж, голомтын болон халдвар нэмэгдэх болсон энэ үед эрсдэлийг эрүүл мэндийн даатгалын сангаас тодорхой хэмжээгээр хуваалцах талаар Сангийн яам, Эрүүл мэндийн яамны саналыг үндэслэн шаардлагатай эм тариа, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн зарим зардлыг санхүүжүүлэхээр журамд нэмж тусгав. Үүнд эрсдэлийн сангаас 2020 онд 9.6 тэрбум төгрөг зарцуулсан. Уг зардлаар нийт 16 аймаг, дүүрэг: Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Орхон, Хөвсгөл, Завхан, Сүхбаатар, Төв /Багануур дүүрэг/, Хэнтий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь аймгуудын нэгдсэн эмнэлгүүдэд эмчилгээ, хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авсан байна. Энэхүү арга хэмжээ нь зайлшгүй шаардлагын улмаас авсан нэг удаагийн арга хэмжээ бөгөөд цаашдаа эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй гэж Үндэсний зөвлөлөөс үзсэн болно.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналд сангийн орлогын 8 хувиар тооцож 48.6 тэрбум төгрөгөөр эрсдэлийн санг зарлагын бүрэлдэхүүнд тусган хүргүүлээд байна.

г/ Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар шинээр байгуулагдах үед Нийгмийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг Капитал банканд харилцах, хадгаламж хэлбэртэйгээр байршуулсан 132.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө шилжин ирсэн.

Монголбанкны ерөнхийлөгчийн 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А-96 дугаар тушаалаар “Капитал банк” ХХК-ийг албадан татан буулгахтай холбогдуулан хуульд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас

Банкны эрх хүлээн авагчид 2019 оны 05 дугаар сард нэхэмжлэлийн шаардлага хүргүүлж, Капитал банкны эрх хүлээн авагчийн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 1679 дүгээр албан бичгээр нэхэмжлэлийн шаардлагын хэмжээ 136,113,246,755,6 төгрөгөөр баталгаажсан. Капитал банк татан буугдсанаар эрүүл мэндийн даатгалын санд томоохон хохирол учирсан бөгөөд ЭМДҮЗ нь даатгалын сангийн хөрөнгийг олж авах талаар дэс дараатай арга хэмжээ авч ирсэн бөгөөд 2020 онд дараах арга хэмжээг авлаа. Үүнд:

Капитал банк ХХК Банкны эрх хүлээн авагчаас цаашид зөвхөн зээлийн төлөлтөөр, мөнгөн хэлбэрээр даатгалд учирсан хохирлыг барагдуулах нь хугацаа их шаардах, бүрэн төлөгдөх эсэх нь эргэлзээтэй болох тул Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт Капитал банкны хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгөөс нэхэмжлэлийн шаардлагад тооцож, өмчлөх эрх гаргаж, шилжүүлэн авах хэлбэрээр төлбөр барагдуулах санал болгон хөрөнгийн жагсаалт гаргаж ирүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь хууль, эрх зүйн хүрээнд сангийн хохирлыг шуурхай барагдуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Авлага барагдуулах асуудлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцсэн юм. Уг хуралдаанаар нөхцөл байдлыг харгалзан сангийн мөнгөн хадгаламжийн тодорхой хэсгийг үл хөдлөх хөрөнгө, түүний дотор орон нутгийн эрүүл мэндийн даатгалын байгууллагуудад конторын зориулалттай барилгыг авах боломжийг ашиглахыг ийнхүү зарчмын хувьд дэмжсэн болно.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл энэ тухай саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан ёсоор тавьсан. Энэ талаар Засгийн газар зохих чиглэл гаргаж, ялангуяа хөрөнгийн бүртгэл, ашиглалтын асуудлыг санд хохиролгүй байхаар шийдвэрлэж, эрхзүйн туслалцаа үзүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Одоогоор Эрүүл мэндийн даатгалын санд Капитал банк ХХК-аар 823.2 сая төгрөг төлүүлээд байна. Цаашид эрүүл мэндийн даатгалын санд аливаа хэлбэрээр хохирол гаргуулахгүй байх талаар хяналт, хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай байна.

д/ Хуулийн дагуу төр шимтгэлийг нь хариуцан төлөх үүрэгтэй шимтгэл төлөгчдийн шимтгэлийн төлбөрийг Сангийн яамнаас сүүлийн 3 жил дараалан дутуу тооцсоноос 210.0 тэрбум төгрөгийн авлагатай гарсан гэж Үндэсний зөвлөл үздэг. Энэхүү авлага нь 0-18 насны хүүхдийн ЭМД-ын шимтгэлийг тооцож төлөхдөө хүүхдийн тоог бууруулж тооцох, тухайн жилд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс үндэслэн шимтгэлийн хэмжээг төлөх хуультай байтал өмнө оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бодож тооцсоны улмаас үүссэн зөрүү буюу дутуу төлөлт юм. Энэ тухай 2019 оны Үндэсний зөвлөлийн тайлан хэлэлцэх үед УИХ-ын Байнгын хороонд танилцуулсан бөгөөд өмнө нь ч ЭМДЕГ-аас өгсөн мэдээ, тайлангуудад тусгагдаж байсан болно.

1.1.2 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр

Үндэсний зөвлөлөөс төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тарифын ялгааг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулан, холбогдох шийдвэрийг батлан гаргаж, 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс улсын хэмжээнд нэг мөр хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн салбарын хууль, эрхзүйн шинэчлэлээр төр хариуцах тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сан руу шилжүүлэн стратегийн худалдан авагчийн тогтолцоонд шилжих өөрчлөлтийг эхлүүлэв. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтын болон төлбөрийн хяналтын үүргийг биелүүлж, стандартын шаардлага хангасан тусламж, үйлчилгээг худалдан авагч болох юм.

Тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд санхүүжүүлэгч байгууллагын шаардлага, санхүүжилтийн хөшүүрэг маш чухал үүрэгтэй болохыг олон улсын судалгаа харуулж байгаа билээ. Энэхүү шаардлагын улмаас олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг эрүүл мэндийн байгууллагууд, эмч нар ашиглах шаардлага тулгарч байна. Олон улсад хамгийн өргөн хэрэглэгддэг цахим платформ нь “UpToDate” бөгөөд үүнийг дэлхийн 191 орны 37500 эрүүл мэндийн байгууллага, 1.7 сая эмч хэрэглэдэг байна. Ийм болохоор олон улсын байгууллагуудын боловсруулсан эмнэлзүйн удирдамжуудыг нэгтгэсэн энэхүү цахим платформыг Монгол Улсын Засгийн газраас манай улсын бүх шатны эмч мэргэжилтнүүд ашиглахыг зорилт болгосны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс хэрэгжилтийг хангах талаар шийдвэр гаргав.

а/ Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, даатгуулагчийн эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор ЭМДҮЗ-ийн 2018 оны 11, 17 дугаар тогтоолоор 18 бүлгийн мэс заслын өвчний үед хэрэглэх 484 нэр төрлийн өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ, шаардлагатай зарим эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн үнийн дээд хязгаарыг 5.0-33.0 сая төгрөгөөр тогтоож, даатгалын сангаас 75 хувийн зардлын төлбөрийг хариуцаж байв. Даатгуулагчдыг даатгалын сангаас дэмжихийн тулд Үндэсний зөвлөл 251 эмнэлгийн хэрэгслийг шинээр нэмж, 650 эмнэлгийн хэрэгслийн үнийг 5.0-45.0 сая төгрөгөөр тогтоож, өмнөх заавар, шийдвэрээ шинэчлэн батлав.

Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээг даатгалын гэрээ бүхий улсын 11, хувийн хэвшлийн 9 эмнэлэгтэй гэрээ байгуулан, 75 хувийн зардлын төлбөрийг даатгалын сангаас хариуцан төлж байна. Өндөр өртөгтэй үйлчилгээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 32.4 мянган даатгуулагчид 41.5 тэрбум төгрөгийг зарцууллаа.

Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний зардлыг даатгалын сангаас олгосноор өндөр өртөгтэй мэс засал хийлгэх боломж даатгуулагчдад гарч, эрүүл мэндийн даатгалд итгэх итгэл дээшилж, гадаад руу чиглэсэн эрүүл мэндийн зардлын урсгал багасах зэрэг нийгэм, эдийн засгийн эерэг үр дагавар үзүүлнэ гэж тооцож байна.

**Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээг үзүүлж буй эмнэлгүүд,
2018-2020 он, сая төгрөгөөр**

Хүснэгт.2.

№	Эмнэлгийн нэр	2018 он		2019 он		2020 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
Улсын эмнэлэг							
1	Улсын I төв эмнэлэг	3 987	4 136.0	5 146	4 831.4	6554	6 979.2
2	Улсын II төв эмнэлэг	2 092	1 822.5	2 582	2 411.8	3251	3 275.3
3	Улсын III төв эмнэлэг	6 274	11 745.1	8 084	12 966.0	7753	13 995.5
4	Гэмтэл, согог судлалын үндэсний төв	6447	10 751.3	7 892	9 145.4	8380	9 470.1
5	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	451	550.7	445	559.9	609	531.6
6	Хавдар судлалын үндэсний төв	2 867	3 740.8	3 887	4 584.3	3647	5 439.5
7	Нийслэлийн өргөө амаржих газар	254	186.6	519	194.6	534	202.2
8	Цэргийн төв эмнэлэг	320	250.6	726	606.9	136	39.1
9	Нийслэлийн Амгалан амаржих газар			77	53.5	136	112.1
10	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг			167	373.3	820	1 088.2
11	Халдварт ӨСҮТ					286	131.3
	ДҮН	22 692	33 183.6	29 525	35 727.1	32 106	41 264.1
Хувийн хэвшлийн эмнэлэг							
1	Гурван гал эмнэлэг			9	2.7	49	11.2
2	Натул эмнэлэг			118	22.3	63	10.0
3	Топаз эмнэлэг			11	1.5	21	6.5
4	Мөнгөн гүүр эмнэлэг			25	27.2	13	11.4
5	ЭМЖЖ эмнэлэг			13	99.9	34	200.0
6	Номун эмнэлэг			79	50.6	27	28.1
7	Болор мэлтий					14	36.6
8	Сонгдо					39	14.3
9	Гранд мед төв					53	10.5
	ДҮН	-	-	255	202.7	313	328.6

Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний зардал өсч, тусламж, үйлчилгээнд хамрагдах даатгуулагчийн тоо нэмэгдэх, даатгуулагчдыг эрсдэлээс хамгаалах сайн талтай болохын зэрэгцээ даатгалын санд ирээдүйд багагүй ачаалал үүсч болох эрсдэлээс сэрэмжлэх шаардлагатай гэж үзээд ЭМДҮЗ ойрын болон дунд хугацаанд төсөв, санхүүгийн нөлөөллийн байдлын судалгааг хийж байна.

б/ Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т Улсын Их Хурлаас 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар даатгуулагч эрүүл мэндийн байгууллагын бүх шатлалын эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий нэршлийн эмийг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмийн сан, бусад эмийн сангаас худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр нэмэлт, өөрчлөлт оруулсан заалтыг хэрэгжүүлэх журмуудыг Үндэсний зөвлөл баталж, 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

“Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ”-г Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл тогтоож, 2020 оны 13 дугаар тогтоолоор 141 ерөнхий нэршлийн, 541 худалдааны нэрийн эмэнд 30, 50, 70 хувийн хөнгөлөлтийг үзүүлэх болсон юм. Даатгалын гэрээтэй эмийн сангийн тоо өмнөхөөс 1.7 дахин нэмэгдлээ. Эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлж байна. Иргэн, даатгуулагчид өөрт хамгийн ойр байгаа эмийн сангаас эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг хүндрэл, чирэгдэлгүй авах боломжтой болсон.

Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал, 2018-2020 он, сая төгрөгөөр

Хүснэгт.3.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал	2018 он		2019 он		2020 он	
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал /сая төгрөг/	30,881.6	25,914.0	33,987.3	33,401.6	43,228.8	35,934.3
Эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн тоо /мян.хүн/	1 435.5		1 593.9		1 524.6	

2019 онд эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 1.5 сая даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 33.4 тэрбум төгрөгийг зарцуулж байсан бол 2020 онд 1627 эмийн сантай даатгалын гэрээ байгуулан 1.5 сая даатгуулагчид 35.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 2.5 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн талаар баримтлах тодорхой бодлогогүй явж ирсэн болон эм, эмийн хэрэгсэл ханган нийлүүлэх болон эмийн жижиглэн худалдаа эрхэлдэг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт сулаас эмийн үнэлгээний талаар маргаан үүсэх, эмийн үнэ өсч, иргэдэд санхүүгийн хүндрэл учрах нөхцөл одоогоор бүрэн арилаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл зөвхөн хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг тогтоож байна. 2020 онд Эм, эмнэлгийн хэрэгслийн агентлаг байгуулагдснаар эмийн үнийг Засгийн газраас тогтоох замаар асуудлыг нэг мөр шийдвэрлэгдэх боломж гарна гэсэн хүлээлттэй байна.

Одоогийн бидний бодлого даатгуулагчийг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхээсээ илүүтэй эм хэрэглээг дэмжсэн шинжтэй байж болзошгүйд дүгнэлт хийх шаардлагатай. Юуны өмнө эмийн хөнгөлөлт ба хэрэглээг өөгшүүлсэн

сурталчилгааг аль болохоор хумиж, цаашид эмийн хэрэглээг багасгах чиглэл баримтлан ажиллах болно.

в/ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ

Иргэн даатгуулагчдад хамгийн ойр ажилладаг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг ЭМДҮЗ бодлогоор дэмжиж ажиллалаа. Тэдний зарим үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөр олгохоор заасан. Мөн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах шинээр 4 төрлийн тусламж, үйлчилгээг нэмж үзүүлэх болсон юм. Үүнтэй холбогдуулан Үндэсний зөвлөлөөс “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах журам”-ыг шинэчлэв.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2018-2020 он

Хүснэгт.4.

Тусламж, үйлчилгээний төрөл	2018 он		2019 он		2020 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/
Сэргээн засах тусламж, үйлчилгээ	42,838	946.3	70,794	1 957.2	59,763	2,230.4
Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	7,538	188.5	41,545	1 286.5	38,189	1,513.7
Өдрийн эмчилгээ	7,259	217.6	52,871	2 013.4	59,052	3,930.0
Оношилгоо шинжилгээ	24,571	368.7	287, 418	2729.0	340,376	4,015.2
Нийт дүн	82,206	1,720.1	452,628	8,986.1	497,380	11,690.4

Даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг шинэчилж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 20.0 мянган төгрөг байсныг 45.0 мянган төгрөг болгон 2.2 дахин, өдрийн эмчилгээнд 30.0 мянган төгрөг байсныг 70.0 мянган төгрөг болгон 2.3 дахин, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийг 25.0 мянган төгрөг байсныг 50.0-70.0 мянган төгрөг болгож 2-2.8 дахин тус тус нэмэгдүүлсэн. Үүнтэй уялдуулан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний жагсаалт, төлбөрийн дээд хязгаар болон өдрийн эмчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл шинээр баталсан. Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, оношилгоо, шинжилгээний дээд хязгаарыг шинжилгээ бүрээр тогтоож өгснөөр даатгуулагчид нэн шаардлагатай анхан шатны тусламж, үйлчилгээг өөрт нь ойр байгаа анхан

шатны эрүүл мэндийн төвөөс хүндрэл, чирэгдэлгүй авахын зэрэгцээ өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирч, анхан шатны тусламж, үйлчилгээний чанарт ахиц гаргах, нөгөө талаас даатгалын сангийн хөрөнгийг хяналттай, үр ашигтай зарцуулах боломж бүрдэж байна.


г/ Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо, шинжилгээ

ЭМД-аас бодлогоор дэмжиж буй бас нэг арга хэмжээ бол иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахад чиглэж байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1-т “Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэнийг дэмжиж, тодорхой үечлэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах болов.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам болон үзлэгийн багц”-д 18-34 нас, 35-45 нас, 46-64 нас, 65-аас дээш насны даатгуулагчийг 4 насны үечлэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээ хийлгэж байхаар тогтоолоо.

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо, 2020 он

График.1.



Тайлант онд даатгуулагчийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдлээс хамааруулан урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 2020 онд эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн 156 эрүүл мэндийн байгууллагад давхардсан тоогоор 99.3 мянган даатгуулагч хамрагджээ. Энэ арга хэмжээнд ЭМДС-аас 6.6 тэрбум төгрөг зарцууллаа.

д/ “Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3-т “Элэгний хорт хавдар, хатуурлын улмаас үүсэх нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлж, Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг

баталсан. 2016 оноос хойш тус хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл туслан оролцож, шаардлагатай зарим зардлыг гаргасан.

Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолд элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварын тархалтыг таслан зогсоох “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн II шатны зорилтыг хэрэгжүүлэхээр болсон юм. Энэ зорилтыг хангахын тулд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2019 оны 10 дугаар сард тогтоол гаргаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг тогтоож өгсөн.

Үүнд: Хепатитийн В, С вирусийн анхдагч илрүүлэг шинжилгээний зардлыг 3500 төгрөгөөр, хепатитийн В, С вирусийн анхдагч илрүүлэг шинжилгээний хариу сул эерэг, эргэлзээтэй гарсан тохиолдолд илрүүлгийн нэмэлт шинжилгээний зардлыг 5.0-10.0 мянган төгрөгөөр, хепатитийн В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээний дээд хязгаарыг хагас автоматаар тодорхойлоход 80.0 мянган төгрөг, бүрэн автоматаар тодорхойлоход 120.0 мянган төгрөг, хепатитийн D вирусийн илрүүлэг шинжилгээний зардлыг 15.0 мянган төгрөг, идэвхжил тодорхойлох шинжилгээний төлбөрийн дээд хязгаарыг 120.0 мянган төгрөгөөр тус тус тооцон төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлсэн оношилгоо, шинжилгээний зардлын төлбөрийг даатгалын сангаас бүрэн хариуцаж байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангаас
“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт зарцуулсан зардал, 2018-2020 он**

Хүснэгт.5.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт зарцуулсан зардал	2018 он		2019 он		2020 он	
	Хүний тоо, мян	Гүйцэтгэл /сая төг/	Хүний тоо, мян	Гүйцэтгэл /сая төг/	Хүний тоо, мян	Гүйцэтгэл /сая төг/
Элэгний В, С вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт	65.1	11,865.3	28.5	7,146.9	65.3	5,182.5
Элэгний В, С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээний зардал	427.2	1,547.1	1,005.4	686.5	125.1	485.9
Элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээний зардал	56.0	6,449.5	98.7	7,244.6	37.7	3,395.3
Нийт	548.3	19,861.9	1,132.6	15,077.3	228.1	9,063.7

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт 2018 онд 19.8 тэрбум төгрөг, 2019 онд 15.1 тэрбум төгрөг, 2020 онд 9.1 тэрбум төгрөг тус тус зарцуулав. 2020 онд В, С вирусийн илрүүлэг, баталгаажуулах шинжилгээнд 125.1 мянган хүн, В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд 37.7 мянган даатгуулагч хамрагдсан. Эмийн үнийн хөнгөлөлтийг 65.3 мянган даатгуулагчид үзүүлж, 5.2 тэрбум төгрөгийн В, С вирусийн эм олгосон байна.

e/ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг худалдан авах ажиллагааг эрүүл мэндийн даатгалын байгууллага гэрээний үндсэн дээр үе

шаттайгаар гүйцэтгэнэ” гэж заасан. Хуулийн энэхүү заалтын хүрээнд эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн сайдын эрх шилжүүлснээр гемодиализийн тусламж, үйлчилгээ болон “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

2020 онд гемодиализийн тусламж, үйлчилгээг нийт 45.7 мянган тохиолдолд 5.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Гемодиализийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй хувийн эмнэлгүүдийн гүйцэтгэл, 2018-2020 он, сая төгрөг

Хүснэгт.6.

№	Эмнэлгийн нэр	2018 он		2019 он		2020 он	
		Тохиолдлын тоо	Мөнгөн дүн	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн
1	Агапе	4 322	519.1	6 050	698.7	7 361	882.6
2	Интенсивкаре	4 389	506.9	8 478	975.0	13 645	1 569.2
3	Киднейкэр	4 495	534.2	5 494	631.8	6 369	732.4
4	Люксдиализ	6 165	728.2	7 855	903.3	8 643	993.9
5	Улаанбаатармед	2 230	278.7	2 784	342.5	2 848	354.6
6	/Эрин/ Шиномед	2 488	299.7	2 354	269.8	4 093	410.5
7	Интермед	104	13.0	145	16.6	346	38.6
8	Баянзүрх НЭ			633	69.6	1 111	119.7
9	УБТЗ эмнэлэг			344	37.8	1 022	110.1
10	УБ Сонгдо			119	13.7	265	30.5
НИЙТ		24 193	2,875.8	34 220	3,956.0	45 703	5,242.1

Гемодиализийн тусламж, үйлчилгээний 2018-2020 оны төсвийн гүйцэтгэлээс харахад тохиолдлын тоо, зарцуулсан зардал жил бүр өсч, 2020 онд өмнөх оноос дээрх тусламж, үйлчилгээг авсан тохиолдлын тоо 11483-аар, зарцуулсан зардал 1,286.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн сайдын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/107 дугаар тушаалаар амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх тусламж, үйлчилгээг гүйцэтгэх хувийн хэвшлийн шүдний эмнэлгийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хяналт тавих үйл ажиллагааг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлсэн.

Монгол Улсын Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 42/А/88 дугаар тушаалаар 2-12 насны хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэх төлбөрийн хэмжээг 60.0 мянган төгрөгөөр тогтоожээ. Энэ онд нийслэлийн 64, орон нутгийн 83, нийт 147 шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулан ажиллаж байна. 2020 онд “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрт 60131 хүүхэд хамрагдаж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраар дамжуулан улсын төсвөөс 3.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр тооцож олгосон байна.


1.1.3. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн чуулганаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, уг хуулиар агентлаг нь стратегийн худалдан авагчийн тогтолцоонд шилжих шинэ нөхцөл байдал буй болж, хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй байлгах, тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн гүйцэтгэлийг үнэлэх зэрэг хууль, эрх зүйн өргөн хүрээтэй ажиллах үүрэг, зорилттой байгууллага болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 176 дугаар тогтоолоор агентлагийн орон тооны дээд хязгаарыг 170 байхаар шинэчлэн тогтоосон. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх, бодлогын болон үйл ажиллагааны зөв менежмент, маркетингийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг хуульд зааснаар шинэчлэн баталсан.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц

Схем.1.



Үндэсний зөвлөлийн Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг баталсан шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж, 2021 оноос 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг өргөжүүлэн “Эрүүл мэндийн даатгалын хэлтэс”-ийг байгуулан үйл ажиллагаагаа явуулах боллоо.

1.1.4 УИХ-ын Байнгын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн биелэлт

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны тайланг хэлэлцээд Байнгын хороо Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулж тогтоол гарган, эрүүл мэндийн даатгалын бодлогын зарим асуудал, ЭМД-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, бие даасан байдлыг бэхжүүлэх, эрүүл мэндийн даатгалын хөрөнгийг банкинд байршуулах зэрэг арван асуудлаар тодорхой үүрэг, чиглэл протоколоор өгсөн юм.

Уг үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, хийгдэж буй ажил нь:

а/ Үндэсний зөвлөлийн санхүү, төсвийн бие даасан байдлыг хангаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санхүүгийн тайлангаа нэгтгүүлж, санхүүгийн үйлчилгээ авах боломжтой байхаар Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгаж, 2019 оны үйл ажиллагааны тайлантай хамтатган НББСШУ-ны байнгын хороонд хүргүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас ЭМДҮЗ-ийн ажлын албаны үйл ажиллагааг санхүүжүүлэх, ажлын албаны ажилтнуудыг төрийн захиргааны албан хаагчдын статуст оруулах, төсвөө шууд захиран зарцуулж бие даасан ажиллагааг хангах боломжтой байхаар тодорхой асуудлыг Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд тусгагдсан ч эдүгээ шийдвэрлэгдээгүй байна.

б/ Төрөөс цахим системийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд эрүүл мэндийн даатгалын байгууллагад дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх, иргэдийн оролцоог хангах үндэсний цахим сүлжээнд төв, орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг бүрэн хамруулж, цахим програмын хангамжийг шинэчлэн боловсруулах төсөл хөтөлбөрт хамрагдах, зөвлөгөө авах чиглэлээр Засгийн газар болон олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж хамтран ажиллах чиглэл байнгын хороо өгсөн. Энэ дагуу эрүүл мэндийн даатгалын цахим системд орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, байгууллага иргэдийн харилцаанд нэвтэрч байгаа цахим системтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоо бүхий цахим системийг буй болгохоор ажиллаж байна. /Энэ талаар тайлангийн 3.2 дахь хэсэгт тодорхой дурдлаа/

в/ Байнгын хорооноос эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахын давуу талыг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх чиглэл өгсөн билээ.

Урьд онуудад эрүүл мэндийн даатгалын хамралтын байдлын тоог давхардсан тоогоор гаргадаг байсныг цахим системийг шинээр нэвтрүүлж, 2018-2020 онд эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоог давхардалгүйгээр гаргаж байна. Үр дүн нь даатгалд хамрагдагсад 2017 оноос 160.0 орчим мянган хүнээр буурч хүн амын 88.9 хувь болсон бөгөөд 2020 онд зохиосон ажлын үр дүнд 2.9 сая иргэн хамрагдаж, хамралтын хувь 90.9 хувьд хүрлээ.

г/ Эрүүл мэндийн даатгалын сангийн арилжааны банкуудад байршуулж буй хадгаламжийн хүүгийн зөрүүтэй байдалд дүгнэлт хийж, хүүгийн хэлбэлзлэлийг бууруулах арга хэмжээ авах чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл тодорхой арга хэмжээ авлаа. “Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банкинд хадгалуулах, Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах журам”-ыг шинэчилсэн. Тайлант онд ЭМД-ын сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулах тухай ЭМДҮЗ-ийн 2020 оны 3 дугаар тогтоол батлагдан, арилжааны 7 банкттай 12 хадгаламжийн гэрээ байгуулан, 350.0 тэрбум төгрөгийг 12.26 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр байршуулсан. Хугацаатай хадгаламжийн дансны хүүгийн орлого 31.2 тэрбум төгрөгийг ЭМД-ын санд төвлөрүүлэв.

д/ Жил бүрийн эхэнд Үндэсний зөвлөлийн хуралдаанаар банкинд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн түвшинг банк тус бүрээр батлах, тухайн банкинд байршуулах хадгаламжийн хэмжээ, хүүгийн хувийг тогтоохдоо банкны зохистой харьцааг хангаж байгаа эсэх, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь тооцдог байхын тулд ЭМДҮЗ 2020 оны эхэнд 448.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулахаар тогтоож, ингэхдээ банкинд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн түвшин, Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь банк тус бүрээр авч үзэж шийдвэр гаргасан юм.

/УИХ-ын Байнгын хорооны шийдвэр, чиглэлийн биелэлтийг хавсаргав. Хавсралт 2./

1.1.5 ЭМДҮЗ-ийн үйл ажиллагаа

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, орон нутагт аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрддэг хуулийн зохицуулалттай.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, санхүүгийн тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх, тусламж, үйлчилгээний нэр төрлийг тогтоох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрүүл мэндийн даатгалтай холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зэрэг хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2018 оноос УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооноос баталсан бүтэц, орон тооны дагуу ажлын албатай, 12 орон тоонд багтааж үйл ажиллагаа явуулдаг. Ажлын алба нь Эрүүл мэндийн даатгалын

үндэсний зөвлөлийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах чиг үүрэгтэй байгууллага юм.

2020 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 11 удаагийн хуралдаан зохион байгуулж, нийт 29 асуудал хэлэлцэж, 22 тогтоол гаргасан.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 4 актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулан, улсын бүртгэлд бүртгүүлж, 1 актыг нэмэлт өөрчлөлтийн хөдөлгөөн хийлгэсэн. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Журам батлах тухай” 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоол /Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам/

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоол /Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн жагсаалт/

- “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 11 дүгээр тогтоол

- “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоол

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2018, 2019 оны үйл ажиллагааны тайлангаа УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэв. Байнгын хороо, Засгийн газарт тодорхой үүрэг, чиглэл бүхий шийдвэр гаргаж өгсөн юм. Уг шийдвэрийн биелэлтийг тусгайлан гаргав. Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн мэдээг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраар гаргуулан Байнгын хороонд улирал тутам хүргүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 2 тогтоол гаргасан бөгөөд Ажлын алба ажилтнуудыг томилох, чөлөөлөх, хяналт, шалгалтыг явуулах, төсөв, санхүүгийн зарцуулалт, албаны дотоод үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар 18 тушаал гаргасан байна. Үндэсний зөвлөл ажлаа жилээр төлөвлөж, 2020 оны төлөвлөгөөнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 95.6 хувийн биелэлттэй байна. Зөвлөлийн гишүүд, ажлын албаны ажилтнуудтай хамтран Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудын эрүүл мэндийн даатгалын тасгийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудын үйл ажиллагаа, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгуулав.

Ажлын алба Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Баримт бичгийн улсын стандартын дагуу 115 албан бичиг, 7 өргөдөл хүлээн авч, бүртгэл хяналтын

карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, иргэдэд 111 албан бичиг явуулсан байна. Архивын нөхөн бүрдүүлэлт 26 нэгжээр нэмэгдэж, архивд 83 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

2020 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн батлагдсан төсөв 380.9 сая төгрөгөөс 239.4 сая төгрөгийг зарцуулан, Төсвийн тухай хуулийг баримтлан ажиллаж, санхүүгийн өр төлбөр, авлагагүй үүсгээгүй бөгөөд Зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас аудит хийж, зөрчилгүй үнэлэлт, дүгнэлт өгсөн.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, ажилтнууд шинээр авч байгаатай холбогдуулан Үндэсний зөвлөл дараах чиглэлээр хяналт шинжилгээ явуулахаар төлөвлөж байна. Ерөнхий газарт чадварлаг, мэргэжлийн хүний нөөцийг Төрийн албаны хуулийн дагуу сонгон шалгаруулж авах, танил тал, найз, нөхөд, мөнгө харж, гадны шахалтаар мэргэжлийн ур чадваргүй, ажилд тэнцэхгүй хүмүүсийг авч ажиллуулдаг асуудлыг таслан зогсоох; Ерөнхий газрын ажилтнуудын хамтач ажиллагааг сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэх энэ хүрээнд ажилтны албан тушаалын тодорхойлолт, стандартыг шинэчлэн гаргуулах, ажлын албадын ажил үүрэг гүйцэтгэх чадавхийг өндөржүүлэх, бүтээлч ажиллагаатай хамт олныг бүрдүүлэх; дотоод хяналтыг сайжруулах; хүнд суртал, чирэгдлийг арилгах, ашиг сонирхлын зөрчилгүй, авлигагүй орчин бүрдүүлэх; ажилтнуудыг сургаж бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх; ажиллах нөхцөлийг сайжруулах, зэрэг дэв, урамшууллын системийг боловсронгуй болгох зэргээр бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлийн ажлыг тавигдаж буй шаардлагын түвшинд явуулах зорилт тавьж байна.

Мөн Үндэсний зөвлөлийн гишүүдийн оролцоотой орон нутаг, нийслэлд ЭМДҮЗ-ийн гаргасан шийдвэрүүдийн биелэлт хэрхэн хангагдаж буй талаар хэсэгчилсэн хяналт шалгалт хийх болно.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг байгуулсан. Энэ шийдвэрээр 2018 оны эхнээс нийгмийн даатгалын байгууллагын хариуцаж байсан эрүүл мэндийн даатгалын чиг үүргийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын байгууллага хэрэгжүүлэх болсон юм. Нийгмийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн даатгалын санг тусгаарлах үед 444.0 тэрбум төгрөгийн харилцах болон хадгаламж, 31.2 тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд, нийтдээ 475.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцах болсон юм.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогын хэмжээг 506.5 тэрбум төгрөг,

үүнээс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого 448.9 тэрбум төгрөг, бусад орлого 57.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгдөв. Харин даатгалын төсвийн нийт зарлага 494.5 тэрбум төгрөг, үүнээс тусламж, үйлчилгээний зардалд 467.8 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 5.4 тэрбум төгрөг, эрсдэлийн сангийн зардалд 20.0 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад 1.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан.

2020 онд Эрүүл мэндийн даатгалын санд 476.5 тэрбум төгрөг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 94 хувьтай байна. Үүнээс шимтгэлийн орлого 420.5 тэрбум төгрөг, бусад орлого буюу чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүүгийн орлого, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд ногдуулсан алдангийн орлого 55.7 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэв. /Орлого, зарлагын дэлгэрэнгүй хүснэгтийг хавсаргав. Хавсралт 3./

**Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл,
2018-2020 он, сая төгрөгөөр**

Хүснэгт.7.

Эрүүл мэндийн даатгалын сан		2018 он		2019 он		2020 он	
		Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
А. ОРЛОГО		376,011.9	422,340.2	407,667.3	469,419.8	506,538.2	476,515.4
1	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	336,684.6	374,745.1	368,334.6	426,881.0	448,903.8	420,510.8
2	Бусад орлого	39,327.3	47,595.1	39,332.7	42,538.8	57,634.4	55,710.1
3	Капиталаас авах авлага	-	-	-	-	-	823.2
Б. ЗАРЛАГА		341,330.60	311,725.9	407,667.3	350,956.4	494,538.3	426,379.5
1	Тусламж, үйлчилгээний зардал	337,039.1	308,171.0	399,171.3	346,127.8	467,759.9	410,725.6
2	Үйл ажиллагааны зардал	4,017.9	3,379.1	5,422.4	4,569.1	5,438.4	4,749.3
3	ШШБА-ны урамшуулал	33.6	5.5	800.0	0.5	-	-
4	НДЕГ-т					1,100.0	1,100.0
5	Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт	240.0	170.3	273.6	259.0	240.0	204.6
6	Эрсдэлийн сангийн хөрөнгө	-	-	-	-	20,000.0	9,600.0

Эрүүл мэндийн даатгалын сангаас 410.7 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний зардлыг гүйцэтгэлээр тооцон бүрэн олгож, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 4.7 тэрбум төгрөг, бусад зардалд 11.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг үндэслэн илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргасан даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын сангаас 204.6 сая төгрөгийг буцаан олгосон байна.

2018-2020 онд давхардсан тоогоор 25,762.9 сая даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нийтдээ 1,066.8 тэрбум төгрөгийг зарцууллаа. Бүхэлдээ ЭМД-ын сангийн орлого нь зарлагаа бүрэн нөхөж, жил бүрийн төсвийн хуулинд тусгагдсан санхүүжилтийг хийж даатгалын сан 475.0-617.2 тэрбум төгрөгийн үлдэгдэл нөөцтэй ажиллаж ирлээ. Харин 2021 оноос эхлэн Эрүүл

мэндийн даатгалын сангийн төсвийн хуулиар ЭМД төлөгчдийн шимтгэлийн сан, төсвийн зориулалтын хөрөнгийг стратегийн нэг худалдан авалтын тогтолцоонд шилжүүлэн төвлөрүүлж, даатгуулагчид болон иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад зарцуулах нэгдсэн бодлогоор хангаж ажиллах болов.

Эрүүл мэндийн даатгалын төсөв, түүний гүйцэтгэлийн байдлыг өмнөх жилүүдийн байдалтай харьцуулахад сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн даатгалд даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувь хэмжээг он тус бүрд нэмэгдүүлээгүй ч 2018, 2019 онуудад сангийн орлого жил дараалан 38.0-61.6 тэрбум төгрөгөөр өссөн. Харин 2020 онд шимтгэлийн орлого төлөвлөгөөнөөс 28.4 тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнээс ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл 7 хувиар, бусад даатгуулагчийн төлөх шимтгэл 24.2 хувиар төлөвлөгөө тасалдсан нь халдварт цар тахлын үед аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдож, иргэдийн орлого буурсантай холбоотой. Нөгөө талаар зохион байгуулалтын болон цаг үеийн бэрхшээлтэй нөхцөлд авах арга хэмжээ хангалттай байж чадаагүй явдал ч нөлөөлсөн байх талтай.

2.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Монгол Улсын бүх иргэн эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоож байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллага, ажилтны сард төлөх шимтгэлийн хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар, бусад даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар тогтоохоор тус тус заасан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл шимтгэлийн хувь хэмжээг 2018-2020 онуудад нэмэгдүүлэхгүй байх бодлого баримталсан. Энэ талаарх саналаа жил бүр Монгол улсын Засгийн газарт хүргүүлж, Засгийн газрын 2019 оны 477 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2020 оны хэмжээ”-г шинэчлэн тогтоосон юм.

Шимтгэл төлөлтийн энэ байдал нь ЭМД-ын шимтгэл төлөгч ажил олгогч болон даатгуулагч иргэдэд дарамт үзүүлэхээргүй байж зөвхөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлтөөс өөрөөр шимтгэлийн хувь хэмжээг хэвээр хадгалах бодлогыг Үндэсний зөвлөл баримталсан нь даатгалын санд хангалттай нөөц буй болсонтой холбоотой. Цаашид зарлагыг зөв оновчтой зохицуулвал ойрын үед даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх шаардлага гарахгүй байх боломжтой байна.

Эрүүл мэндийн даатгалын 2018-2020 оны шимтгэлийн хувь, хэмжээ**Хүснэгт.8.**

№	Даатгуулагчдын төрөл	Шимтгэлийн 2018 оны хэмжээ	Шимтгэлийн 2019 оны хэмжээ	Шимтгэлийн 2020 оны хэмжээ	Төлөх хугацаа
1	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын хувиар, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь			Сар бүр
2	0-18 насны хүүхэд				Хагас, эсхүл бүтэн жилээр
3	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	2400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн	2400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	
5	Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн	4800 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	6400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	8400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	Сар бүр

2.3. Эрүүл мэндийн даатгалын хамралт

Тайлант онд 2999.7 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын түвшин 90.9 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, хамрах хүрээг өргөтгөх, сангийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах зорилгоор төрийн дор дурдсан байгууллагуудтай 2018 оноос эхлэн “Хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий газартай Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.4 дэх заалтыг хэрэгжүүлэх, шимтгэлийн орлогыг цуглуулж баталгаажуулах, төвлөрүүлэх, уг хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэх, тайлагнах ажлыг гүйцэтгэх харилцааг зохицуулах;
- Улсын бүртгэлийн ерөнхий газартай 0-18 насны хүүхдийн мэдээллийг солилцох;
- Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газартай Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах;
- Хил хамгаалах ерөнхий газар болон Зэвсэгт хүчний жанжин штабтай цэргийн жинхэнэ алба хаагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран ял эдэлж байгаа ялтныг эрүүл мэндийн даатгалд хамруулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах иргэдийн мэдээллийг “Төр хариуцах иргэдийн бүртгэлийн програм”-д бүртгэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах нөхцлийг бүрдүүлэн холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүний тоо 2019 онд 2018 оноос 96.1 мянган даатгуулагчаар буюу 1.3 хувиар, 2020 онд өмнөх оноос 79.1 мянган даатгуулагчаар буюу 0.7 хувиар тус тус нэмэгдлээ.

Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал, 2018-2020 он

Хүснэгт.9.

№	Хамралтын төрөл	Даатгуулагчийн тоо /мянган хүн/		
		2018 он	2019 он	2020 он
1	Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан	745.2	735.0	831.2
2	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн	175.0	119.4	162.5
3	Их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч	47.2	19.7	25.6
4	Малчин	93.0	67.6	76.2
5	Гадаадын харьяалалтай иргэн	0.1	0.2	0.1
6	ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн	1,761.4	1,978.7	1902.8
7	Ял эдэлж буй хоригдол	2.8	-	1.1
Нийт		2,824.7	2,920.6	2,999.7
Хувь		88.9	90.2	90.9

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн, малчин, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын хамралт нэмэгдэж, харин эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцдаг иргэний эрүүл мэндийн даатгалын хамралт буурч байгаад дүгнэлт хийж, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах ажиллагааг сайжруулах шаардлага гарч байна.

2.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт, сангаас төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний зардалд 2019 онд 399.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 346.1 тэрбум төгрөгийг зарцуулж байсан бол 2020 онд 467.8 тэрбум төгрөг төлөвлөж, давхардсан тоогоор 9.7 сая даатгуулагчид 410.7 тэрбум төгрөг зарцуулсан. Үүнд: төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад 268.4 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлэх зардалд 58.0 тэрбум төгрөг, рашаан сувиллаар үйлчлүүлэх зардалд 21.1 тэрбум төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний зардалд 11.7 тэрбум төгрөг, зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 35.9 тэрбум төгрөг, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардалд 6.5 тэрбум төгрөг, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн зардалд 9.0 тэрбум төгрөг тус тус зарцууллаа.

Эрүүл мэндийн даатгалын төсвийн тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлээс харахад 43.6 тэрбум төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байгаагаас “Элэг бүтэн Монгол хөтөлбөр”-ийн зардлаас 30.8 хувь буюу 4.0 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлэх даатгуулагчийн зардлаас 18 хувь буюу 12.7 тэрбум төгрөг, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг 8.1 хувь буюу

0.6 тэрбум төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, оношилгоо шинжилгээний зардлаас 26.4 хувь буюу 4.2 тэрбум төгрөг зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан даатгуулагчийн тоо, зарцуулсан хөрөнгө, 2018-2020 он, тэрбум төгрөг

Хүснэгт.10.

№	Тусламж, үйлчилгээний төрөл	2018 он		2019 он		2020 он	
		Даатгуулагчийн тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө	Даатгуулагчийн тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө	Даатгуулагчийн тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө
1	Хэвтэн эмчлүүлэх	507.3	125.7	527.2	129.9	497.8	152.9
2	Амбулатори	2,808.5	43.5	3,248.0	50.7	3,221.9	54.4
3	Өдрийн эмчилгээ	28.4	3.4	29.0	4.0	35.0	3.6
4	Оношлогоо, шинжилгээ	1,759.8	34.9	2,243.7	42.7	3,227.1	53.0
5	Уламжлалт эмчилгээ	29.7	3.4	34.2	4.3	38.7	8.4
6	Хөнгөвчлөх эмчилгээ	5.6	1.7	7.2	2.2	8.6	3.2
7	Нөхөн сэргээх үйлчилгээ /сувилал/	98.1	10.8	109.0	11.9	107.5	21.1
8	Эмийн үнийн хөнгөлөлт	1,370.4	25.9	1,565.4	33.4	1,524.6	35.9
9	Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ	22.6	33.2	29.4	36.2	32.0	41.6
10	Хорт хавдрын хими эмчилгээ	4.4	1.2	5.4	2.6	7.2	3.2
11	Хорт хавдрын туяа эмчилгээ	0.2	0.26	0.5	0.54	7.2	0.8
12	Элэгний В, С вирусийн оношилгоо, шинжилгээ	56.0	6.5	41.1	5.3	37.7	3.4
13	Элэгний В, С вирусийн илрүүлэх	427.2	1.5	200.1	0.73	125.1	0.5
14	В,С вирусын эмийн үнийн хөнгөлөлт	65.1	12.2	28.5	7.2	65.3	5.2
15	Урьдчилан сэргийлэх багц	52.3	2.1	100.5	4.0	427.7	6.6
16	ӨЭМТ-ийн тусламж/ү	82.2	1.7	452.6	9.0	433.1	11.7
ЭМД-ын сангийн зарлага		7,317.8	308.2	8,602.7	346.1	9,842.4	410.7

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан даатгуулагчийн тоо 2019 онд 2018 оноос 1284.9 мянган хүнээр, 2020 онд 2019 оныхоос 1239.7 мянган хүнээр тус тус нэмэгдэж, эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцаж байгаа тусламж, үйлчилгээний зардлууд жил бүр нэмэгдэж, даатгуулагч иргэдийн эрсдэлээс хуваалцаж байна.

ЭМДС-ийн тусламж, үйлчилгээний төлөвлөгдсөн зардал хэмнэгдсэн нь Коронавирусын халдварт цар тахлын үед бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор эмнэлгээр үйлчлүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах иргэд цөөрсөнтэй холбоотой. Мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ажлын чанар, тавьж буй шаардлагын түвшинд байж чадахгүй байгаа явдал ч нөлөөлсөн байна.

2020 онд эрүүл мэндийн 2779 байгууллагатай ЭМД-ын байгууллага гэрээтэй ажиллав. Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн үзлэг, оношлогоо,

шинжилгээ, өдрийн эмчилгээ, хорт хавдрын болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, уламжлалт, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээ, өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт, эмнэлгийн хэрэгсэл, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ, хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ, магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээг үзүүлж байна.

Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2018-2020 он

Хүснэгт.11.

№	ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал	2018 он	2019 он	2020 он
1	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	97	102	103
2	Хувийн эмнэлэг	169	179	179
3	Рашаан сувилал	49	58	58
4	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв	292	424	459
5	Эмийн сан	835	1009	1627
6	Элэгний В,С вирусийн идэвхжил тодорхойлох лаборатори	28	28	26
7	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын шинжилгээ	156	150	156
8	Гемодиализийн тусламж, үйлчилгээ	6	11	11
9	“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөр	-	161	147
10	Спорт клуб	-	-	13
Нийт		1632	2122	2779

Тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын тоо 2019 онд нь 2018 онтой харьцуулахад 490-өөр, 2020 онд өмнөх оноос 657-оор нэмэгдэв. Даатгуулагч иргэдэд үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын хүртээмж нэмэгдэв. Иргэд даатгуулагчид тусламж, үйлчилгээ авахад хүндрэл, чирэгдэл багассан байна. Эмийн сан 2020 онд 2019 оноос 618-аар өслөө. Хөнгөлөлттэй эмийн жорыг 2020 оны 11 дүгээр сараас эрүүл мэндийн байгууллагын бүх шатлалын эмч нар бичиж, эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эмийн сангуудаар хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ үзүүлэх талаар авсан арга хэмжээ зохих үр дүнд хүрч байна. Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 1627 эмийн сангаар хүргэснээр иргэд-даатгуулагчид өөрт хамгийн ойр байгаа эмийн сангаас эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг авах боломж бүрдсэн.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

3.1 Дотоод хяналт

а/ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө хяналт шалгалтын ажлыг тусган зохион байгуулж байна. 2020 онд ЭМДҮЗ-өөс Эрүүл мэндийн даатгалын мөнгөн хөрөнгийг байршуулах талаар 2019 онд гаргасан тогтоолуудын биелэлтийг шалгах ажлын хэсэг байгуулж, зохих удирдамжийн дагуу тогтоолын биелэлтийг шалгасан. Арилжааны зарим

банкинд байршсан мөнгөн хөрөнгийн байдалд шалгалт хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ЭМДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ЭМДЕГ-т чиглэл өгөв.

Хөнгөлөлт үзүүлэх эм, түүний үнийн дээд хязгаар тогтоох асуудал даатгуулагч иргэд, эмийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын зүгээс гаргасан санал хүсэлтийг барагдуулах талаар тус Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийг томилж, шалгалтын дүнг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Цаашид эм, эмнэлгийн хэрэгслэлийн үнэ тогтоох асуудлаар улсын хэмжээнд болон эм ханган нийлүүлдэг байгууллагыг оролцуулан хийх, шинээр байгуулагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газартай хамтран ажиллах шаардлагатай байна.

Өртгийн жин, үнэ, тарифын судалгаа хийх бодлогын асуудлуудыг шийдвэрлэх, ЭМД-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, Капитал банкны талаар Үндэсний зөвлөлийн гишүүд, ажлын албаны оролцоотой ажлын хэсгүүд байгуулан, хяналт шалгалт хийж, дүнгээ Үндэсний зөвлөлд танилцуулж, холбогдох арга хэмжээ авч байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны даргын 2020 оны А/09 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудын эрүүл мэндийн даатгалын тасгийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудын үйл ажиллагаатай танилцан, ЭМДҮЗ-өөс гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.


Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулж, ажиллах журмыг батлах, холбогдох шийдвэрийг техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн гаргасан.

б/ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд ЭМДЕГ-аас төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулж байна. Энэ шалгалтаар 2020 онд эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий 220 эрүүл мэндийн байгууллагад, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 322 эрүүл мэндийн байгууллагад явуулжээ. Шалгалтаар нийт 41 эрүүл мэндийн байгууллагад 103.8 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 81 эрүүл мэндийн байгууллагад ажил сайжруулахаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ын дагуу эрүүл мэндийн байгууллагуудыг сонгон шалгаруулах тохиолдол бүрт ажлын хэсэг ажиллаж, сонгон шалгаруултад тэнцсэн эрүүл мэндийн байгууллагуудтай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээтэй ажиллажээ.

Шалгалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллага

График.2.



Тайлант онд даатгалын гэрээ байгуулсан төв орон нутгийн 2779 эрүүл мэндийн байгууллагын гэрээг журмын дагуу хуулийн хугацаанд шилэн дансанд мөн эрүүл мэндийн байгууллагын судалгааг шинэчлэн, байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн байна. 2020 оны даатгалын гэрээ эхний хагас жилийн биелэлтийг дүгнэх үйл ажиллагаанд гэрээ байгуулсан төв, орон нутгийн нийт 2060 эрүүл мэндийн байгууллагаас 2036 байгууллага буюу 98,8 хувь нь хамрагджээ.

Магадлан итгэмжлэлийн хугацаа сунгагдаагүй, санхүүжилт аваагүй, заасан хугацаанд гэрээ дүгнэх үйл ажиллагаанд ирээгүй нийт 21 байгууллага, даатгалын гэрээ дүгнэх журмын дагуу 70-аас доош оноогоор үнэлэгдсэн 4 эмийн сан, бүгд 25 байгууллагын гэрээг түдгэлзүүлэх, журмын дагуу 59-өөс доош оноогоор үнэлэгдсэн 9 эмийн сан, 1 шүдний эмнэлэг, Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдаагүй 1, татан буугдсан 1, гэрээ цуцлах хүсэл гаргасан 4, явцын болон хяналт шалгалтын дүгнэлт гарсан 8, бүгд 26 байгууллагын гэрээг цуцлахаар тус тус шийдвэрлэсэн байна.

3.2 Цахим хяналт

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа үндсэндээ цахимжих хэлбэрт шилжив. Энэ талаар Үндэсний зөвлөл, ЭМДЕГ-аас сүүлийн 3 жилд орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, цахим баримтын ситемтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоо бүхий цахим системийг хөгжүүлэхээр зорьж, үр дүн гарч байна.

“Эрүүл мэндийн даатгалын цахим систем”-ийг 2018 оноос “Цахим жор”, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр, “Урьдчилан сэргийлэх үзлэг”, “Өрх, сумын эрүүл мэндийн төв”-ийн дэд програмуудыг үе шаттайгаар амжилттай хэрэгжиж байна.

“Эрүүл мэндийн даатгалын цахим систем”-ийг өргөтгөн “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд”, эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын бүртгэлийн програм “HICS” систем, “Е баримт хэвлэх систем”, “Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний дэд систем”-ийг тус тус шинээр нэвтрүүлж, даатгуулагч иргэдэд зориулсан **edaaatgal** аппликейшн нэвтрүүлж байна. “Ухаалаг утасны аппликейшн”-ийг нэвтрүүлснээр даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын болон даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллага, эмийн сангийн мэдээллийг шаардлагатай үедээ цаг алдалгүй авах боломжтой болов.

Малчин, оюутан, хувиараа хөдөлмөр эрхлэгчид Edaatgal, Ebarimt аппликейшнаар дамжуулан түргэн шуурхай, чирэгдэлгүй, гар утаснаасаа эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх боломжтой болсон. 2020 оны 12 дугаар сарын байдлаар **edaaatgal** аппликейшныг 18328 иргэн ашиглаж байна.

Цахим системд:

- ЭМД-ын тусламж, үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үйлчилгээ авах даатгуулагчдад зориулсан 1818.mn цахим хуудсыг нэвтрүүлсэн.
- Цахим системд холбогдсон хурууны хээ уншигч төхөөрөмжийг 3 нэр төрлөөр нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад хүртээмжтэй байх боломж олгосон.
- Бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөнгөлөлттэй эмийн жор бичих, нарийвчлан хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн.
- Эрх бүхий эмчийн бичсэн хөнгөлөлттэй эмийн цахим жорыг хурууны хээгээр баталгаажуулах үйлчилгээг нэвтрүүллээ.

Ингэснээр эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий эмийн сангууд болон өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгалын цахим жорын систем ашиглан өрхийн эмчийн жор бичилт, эмийн сангийн эм олголтыг эмийн нэр төрөл, өрхийн эмч, эмийн сан, даатгуулагч тус бүрээр цаг, минутаар нь бүртгэж, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэв.

3.1.1 Сургалт, сурталчилгаа

а/ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар гаргасан Засгийн газар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын гаргасан эрх зүйн актууд, дүрэм, журам, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилтыг хангах үүднээс цахим системийг ашиглан сурталчилгаа явуулж, “Хэрэглэгчдэд үйлчлэх төв”-ийг байгуулан ажиллаж байна. 2020 онд тус төвд нийтдээ мэдээлэл лавлагаагаар /1800-1363/ нийт 61503 иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгч, иргэдээс ирүүлсэн 3454 санал гомдлыг шийдвэрлэсний зэрэгцээ тэдэнд мэдээлэл өгч, сурталчилгаа хийсэн юм.

б/ Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд eBarimt аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч, тодорхой хөдөлмөр эрхлээгүй бусад иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн албан журмын

эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх боломжтой болсон талаарх мэдээлэл сурталчилгааг иргэдэд хүргэхээр олон нийтийн сүлжээгээр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах боллоо.

Үр дүнд нь төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн систем eBarimt аппликейшныг ашиглан 2,475 иргэн 108.5 сая төгрөгний эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөнд; мөн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг иргэдэд улам илүү ойртуулах зорилгоор бүхий л мэдээллийг нэг дороос авах, даатгалаас хөнгөлөлт авсан тусламж, үйлчилгээний мэдээллээ харах, хянах, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ цахимаар төлж, энэ аппликейшнийг ашиглаж, 171 иргэн 11.2 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн дүнтэй байна.

в/ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан ёсны www.emd.gov.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаа, эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх тусламж, үйлчилгээ болон цахим системийн талаарх шинэ мэдээллүүд, эрүүл мэндийн байгууллагуудын хаяг байршил зэрэг шаардлагатай мэдээллийг тухай бүрд шуурхай ил тодоор байршуулан иргэд даатгуулагчид болон эрүүл мэндийн байгууллагуудын ажилтнуудыг мэдээ, мэдээллээр хангажээ.

Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр, “Эрүүл шүд, эрүүл хүүхэд” хөтөлбөр, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдсан даатгуулагч иргэдийн тоон мэдээллийг 7 хоног бүр шинэчилж 98 удаагийн инфографик зурган мэдээг нийтлэв. Мөн эмийн хөнгөлөлтийн жагсаалтаас хамгийн их борлуулалттай эмийн тоон мэдээллийг 7 хоног бүр шинэчлэн инфографик зурган мэдээгээр мэдээлж байна.

г/ Тайлант онд мэдээлэл сурталчилгааны чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, телевиз, радио, сонин, сайтад өгөх мэдээ, мэдээлэл, ярилцлагын тоог нэмэгдүүлэхэд анхаарал тавьснаар өнгөрсөн оны мөн үеийнхээс 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр MYOHPT, MYOHP, ТВ25, ТВ5, ТВ9, EAGLE, UBS, SBN, MASS, ӨЛЗИЙ, NTV, STAR, зэрэг 20 гаруй телевиз, “Arslan”, Zалуу.com, unuudur.mn, news.mn, gogo.mn, medee.mn зэрэг сайтуудаар 10 гаруй сайт, Өнөөдөр сонин, Монголын үнэн сонин, Зууны мэдээ зэрэг сониноор дамжуулан эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээ, мэдээлэл, ярилцлага, сурвалжлага, нэвтрүүлэг, шторкийг иргэдэд байнга хүргэдэг боллоо. Энэ ажлын хүрээнд MNB телевиз, Ийгл ТВ, MYOHP зэрэг хэвлэл мэдээллийн 17 байгууллагатай гэрээ байгуулан, хамтран ажиллаж байна.

д/ ЭМДЕГ-ын сургалтын хөтөлбөрийн дагуу болон байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах ерөнхий газарт, МУБИС-ийн салбар 8 сургууль, Найрамдал” Олон улсын Хүүхдийн Цогцолборт, Нийслэлийн 9 дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг байгууллагуудад 30 орчим сургалт зохион байгуулж 10.0 мянга гаруй иргэд, даатгуулагчдыг хамруулан сургалт сурталчилгаа зохион байгуулсан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЦААШДЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ

4.1 Эрүүл мэндийн даатгалын 2020 оны ажлын үр дүн

➤ Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа цаг үеийн тавигдаж буй зайлшгүй шаардлага болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, түүнд шинээр орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн даатгалын харилцааг боловсронгуй болгох, сангийн удирдлага, менежментийг сайжруулахтай холбогдсон журам, зааврыг шинэчлэх, Улсын Их Хурлын байнгын хорооноос гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж даатгалын сангийн үйл ажиллагааг сайжруулахад илүүтэй анхаарсан гэж үзэхээр байна. Мөн өмнө гаргасан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авчээ.

➤ Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоо сүүлийн 3 жилд нэмэгдлээ. 2020 онд эрүүл мэндийн 2779 байгууллагатай гэрээтэй ажиллаж, давхардсан тоогоор 9.8 сая даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлжээ. Энэ нь өмнөх оноос эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо 1.2 сая буюу 14 хувиар, эрүүл мэндийн байгууллага 657 буюу 30 хувиар тус тус өсч, эрүүл мэндийн даатгалын хүртээмж нэмэгдсэн.

➤ Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын гүйцэтгэл 93.6 хувь байгаагийн гол шалтгаан нь цар тахлын нөлөөллөөр үүссэн бөгөөд энэ хэмжээгээр эрүүл мэндийн даатгалын төсөвт алдагдал гарлаа. Шимтгэлийн орлогын хэмжээ буурах гол шалтгаан бол иргэд даатгуулагчдын худалдан авах чадвар багасаж, аж ахуйн нэгж байгууллагын орлого буурч, үйл ажиллагааны зардал болон, татвар, шимтгэлээ төлж чадахгүйд хүрсэнтэй холбоотой юм.

➤ Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тарифын ялгааг арилгаж, ижил хэмжээтэй буюу 400.000 төгрөг болголоо. Ингэснээр төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 33.3 хувиар, хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 128.6 хувь /2.3 дахин/-аар нэмэгдүүлсэн.

➤ Иргэн, даатгуулагчдын эрх ашгийг урьтал болгож, иргэдийг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн даатгалын хөрөнгийг зарцуулахыг бодлогын түвшинд тавьж хэрэгжүүлэх арга хэмжээ авсан чухал алхам болов.

➤ Хөнгөлөлттэй эмийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах арга хэмжээ авлаа. Үүнд зарах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүллээ. Даатгалын гэрээтэй эмийн сангийн тоо өмнөхөөс 1.7 дахин өслөө.

➤ Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн шинэчлэлээр төр хариуцах тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сан руу шилжүүлэн стратегийн худалдан авагчийн тогтолцоонд шилжих өөрчлөлтийн эхлэл тавигдав. Энэхүү шинэчлэлийг өөрийн орны онцлогт нийцүүлэн, сангийн хөрөнгийн зарцуулалтыг

алдагдалд оруулахгүй байхад илүүтэй анхаарах шаардлага гарч байна. Стратегийн худалдан авагч нь ЭМДҮЗ байх бөгөөд гүйцэтгэх байгууллага нь эрүүл мэндийн даатгалын байгууллага байх юм. Худалдан авагч тал харьцангуй бие даан ажиллаж, үйлчилгээ нийлүүлэх талтай үр ашигтай хамтран ажиллах шаардлагатай. Стратегийн худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтын болон төлбөрийн хяналтын тогтолцоог цахимжуулан улмаар олон улсын эмнэлзүйн удирдамжийн дагуу үзүүлсэн тусламж, үйлчилгээг худалдан авах нөхцөл бүрдлээ.

➤ Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг иргэд танин мэдэх, даатгалын байгууллагад илүү ойр ажиллах, бүхий л мэдээллийг нэг дороос авах боломжтой болов. Эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлт авсан тусламж, үйлчилгээний мэдээллээ өөрөө хянах, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ цахимаар төлөх боломж бүрдэж байна. Иргэд гар утасны edaatgal аппликейшнтэй болж, даатгалын шимтгэл төлөх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын болон даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллага, эмийн сангийн мэдээллийг шаардлагатай үедээ цаг алдалгүй авах боломжоор хангагдаж байна.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 176 дугаар тогтоолоор агентлагийн орон тооны дээд хязгаарыг 170 байхаар шинэчлэн тогтоосныг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталлаа. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл явагдаж байна. 2021 оноос 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг 4-5 хүнтэйгээр “Эрүүл мэндийн даатгалын хэлтэс”-ийг байгуулав. Ингэснээрээ Эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу үндэсний хэмжээний бүтэцтэй ажиллах боллоо.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага аймаг, дүүрэгт үйл ажиллагаа явуулахад хүчин мөхөсдөж, иргэдийг ЭМД-д хамруулах ажил бүрэн хийгддэггүй, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, нэг сая гурван зуун мянган хүн ажиллаж амьдарч буй нийслэлд эрүүл мэндийн даатгалын зүгээс даатгуулагчдад туслалцаа үзүүлэх, иргэдтэй биечлэн уулзах, санал хүсэлтийг сонсох ажил орхигдож, малчид, оюутан, суралцагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах, даатгалын орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжийг алдаж байгааг эрүүл мэндийн даатгалын тогтолцоогоор засах боломж нэмэгдэж байна.

➤ Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд болон олон улсын мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын боловсруулсан эмнэлзүйн удирдамжуудыг нэгтгэсэн “UpToDate” цахим платформыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс ашиглах тухай шийдвэрийг гаргаж, манай улсын бүх шатны эмч мэргэжилтнүүд ашиглах боломжтой боллоо.

4.2 Ойрын зорилт, анхаарах асуудал

1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд “Стратегийн худалдан авагчийн тогтолцоо”-нд шилжсэнтэй холбоотой дараах арга хэмжээг авахаар төлөвлөж байна. Үүнд:

- Төр хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэхтэй холбоотой эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг журмыг батлах

- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас даатгуулагчид үзүүлж байгаа төр хариуцах тусламж, үйлчилгээ, амбулатори, оношилгоо шинжилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцаж, хувийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

- Эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ буюу хамтын төлбөрийн хэмжээг оновчтой тогтоох

- Эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээтэй уялдуулан даатгалаас санхүүжүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн батлах

2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх болон сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай.

- ЭМД-ын сангийн зарцуулалтыг оновчтой болгох, төлөвлөлтийг сайжруулах, санг болзошгүй эрсдэлээс хамгаалах

- 2021 оны сангийн орлогын төлөвлөгөө тасарч болзошгүй байна. 2021 оны төсөв 123.0 тэрбум төгрөгийн алдагдалтай батлагдсан болон нөгөө талаас орлого буурах хандлагатай байгаад анхаарах

3. УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооноос зориуд анхаарч төсвийн биелэлтэнд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Капитал банканд хадгаламж хэлбэрээр байршиж байсан 136.2 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулахад Монголбанкнаас дэмжлэг үзүүлэх талаар үүрэг чиглэл өгөх

- Сангийн яамнаас ЭМД-ын санд төр хариуцан төлөх шимтгэлийг сүүлийн 3 жил дараалан дутуу тооцон төлж байснаас үүдсэн 210.0 тэрбум төгрөгийн авлагатай гэж Үндэсний зөвлөл үзэж байгаа тул энэхүү төр шимтгэлийг нь хариуцах шимтгэлийн төсөвт дутуу суулгасан ЭМД-ын сангийн авлагыг төлүүлэх талаар судлаж, Байнгын хороо зохих зөвлөмж, шийдвэр гаргаж өгөх

- Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг эх үүсвэр, зориулалтаар нь ангилан эрүүл мэндийн даатгалын сангийн болон улсын төсвөөс хуваарилж байгаа хөрөнгийг орлого, зарлагаар нь нарийвчлан төсөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаж байхаар төсвийн хуулинд тодорхой тусгаж байх.

---ооОоо---

